

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 4.7 дахь хэсэг нэмсүгэй:

“4.7.Төрийн албан хаагчийн ёс зүйн болон сахилгын хэмжээг тогтоох, түүнийг зөрчсөн тохиолдолд ёс зүйн болон сахилгын хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг Төрийн албан хаагчийн хариуцлагын тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“40 дүгээр зүйл.Ёс зүйн хэм хэмжээ

40.1.Төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн болон сахилгын хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно.

3 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Төрийн албан хаагчийн хариуцлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг